



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/429

Мөрөн сум

Мастеруудын VII наадам зохион явуулах
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Ахмад настны тухай хуулийн 11.1.2, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Нэрлэсэн жилийн хүрээнд “Монголын Мастеруудын биеийн тамир спортын VII наадам”-ыг Хөвсгөл аймагт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, наадмын удирдамжийг хоёр дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Монголын Мастеруудын VII наадам”-ыг удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

3. “Монголын Мастеруудын VII наадам”-ыг Хөвсгөл аймагт зохион байгуулахтай холбогдуулж аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалуудыг 2023 оны 07 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд үнэ төлбөргүй үйлчлэх боломж бүрдүүлэн ажиллах ба тамирчдыг анги танхимд байрлуулахаар зохицуулалт хийж ажиллахыг аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын дарга (Ш.Отгон-Эрдэнэ), Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Очирбат) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар) –т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 11-ны өдрийн А/429 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Батбилгүүн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Г.Нарангэрэл

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Очирбат

(Аймгийн Биеийн тамир спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ш. Отгон-Эрдэнэ

(Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д. Түвшинбаяр

(Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д. Идэрмөнх

(Мөрөн сумын Засаг дарга)

Л. Батцэцэг

(Аймгийн Соёл урлагийн газрын дарга)

Б.Банзрагч

(Аймгийн Хөгжимт драмын театрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Төмөрбаатар

(Аймгийн ахмадын хороо)

Ц.Мөнхсүлд

(Аймгийн Шатрын холбоо)

Б.Шинжээболд

(Аймгийн нийтийн цэнгээнт бүжгийн холбоо)

Б.Ганзориг

(Аймгийн "Өдөн бөмбөг" Бадминтоны холбоо)

Ц.Отгонцэцэг

("Аялгуу" бүжгийн холбоо)

Н. Түмэндэмбэрэл

(Хөвсгөл Дартсын клуб)

З.Ганхуяг

(Аймгийн Ширээний теннисийн холбоо)

Э.Ууганбаяр

("Хоймор нутаг" хөнгөн атлетикийн холбоо)

Г.Хэнмэдэх

(Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн биеийн тамирын багш)

Н.Лхагважав

(Монгол цэргийн нэгдсэн холбооны Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн)

Нарийн бичгийн дарга

Б.Ганчимэг

(Аймгийн биеийн тамир, спортын газрын Нийтийн биеийн тамирын албаны дарга)

оОо